

Уул уурхайн жишиг сургууль Говьсүмбэр аймаг дахь

Политехник коллеж



СЭДЭВ: СУРГАЛТЫН ЧАНАРТ ОЮУТАН
СУРАЛЦАГЧДЫН ХАНДЛАГАД НӨЛӨӨЛӨХ
АРГА ЗАМААР БИЕ ДААН СУРАЛЦАХУЙГ
ДЭМЖИХ

БАДРАЛ МЭНДБАЯР

АВХҮҮ ЧУЛУУНЧИМЭГ

2022 он

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга
замаар бие даан суралцахуйг дэмжих

Бүтэц

Удиртгал

1. Удиртгал
2. Үндэслэл
3. Судалгааны зорилго
4. Судалгааны зорилт
5. Судалгааны аргууд

1. Нэгдүгээр бүлэг

- 1.1. Хандлага гэж юу вэ ?
- 1.2. Нийгмийн тогтсон хандлага
- 1.3. Сурагчийн өөрийн удирдлагатай суралцахуйн онолын тайлбар
- 1.4. Өөрийн удирдлагатай суралцахуйн үндсэн үе шатууд

2. Хоёрдугаар бүлэг

- 2.1. Судалгааны хамрах хүрээ
- 2.2. 2019,2020,2021 оны суралцагчдын англи хэлний түвшин тогтоох шалгалтын харьцуулсан судалгаа
- 2.3. Танхим ба цахим хичээлийн хамрагдалт, оролцоог харьцуулсан түүвэр судалгаа
- 2.4. Цахим хичээлд хандалтын судалгаа

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

Удиртгал

ЮНЕСКО-ийн мэдээлснээр Covid-19 цар тахлын улмаас боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаа анги, танхимд явагдах боломжгүй болж сургуулиа хаасан улсын тоо 2020 оны 3-р сарын 15-нд 53, 4-р сарын 15-нд 190, 5-р сарын 15-ны байдлаар 158 болж байсан. Цар тахлын тархалтын оргил үед дэлхийн нийт суралцагчдын 91,3 хувь нь сургуульд явах боломжгүй, онлайн болон бусад ямар нэгэн хэлбэрээр сургалтаа үргэлжлүүлж, зарим улсад хязгаарлагдмал боломжоос хамаарч сургалт зогсоход хүрч байсан¹. Харин Монгол Улсад 2020 оны 1-р сарын 27-оос энэ хичээлийн жил дуустал боловсролын байгууллагууд өөрсдийн нөөц боломжид суурилан цахим хэлбэрээр сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байсан. Хэдийгээр энэ аюулт өвчний дэгдэлт, хор хөнөөл багасаж сургууль цэцэрлэг бусад сургалтын байгууллага хэвийн горимд шилжсэн ч энэхүү өвчин нь амьдрах чадвар сайтай, илүү тэсвэртэй тул устаж үгүй болох эсэх нь тодорхойгүй, томуугийн вирус шиг цаашид бидний амьдралд оршин байсаар байх магадлал өндөр байна. Эмчлэх арга, вакцин, эмийг туршиж байгаа ч одоогоор баталгаа өгөх боломжгүй гэдгийг эрдэмтэд сануулсаар байгаа энэ үед дэлхийн улс орон бүр боловсролыг удирдахад чиглэсэн өөр өөрийн шинэлгэг стратегийг хэлэлцэж байна. Тиймээс бид бүхэн аливаа эрсдэлт цаг үед бэлэн байж шинэ арга зүй, техник технологийг хичээл сургалтдаа нэвтрүүлж, суралцагч төвтэй сургалтын систем мөн бие даасан хариуцлагатай байдлыг оюутан суралцагчиддаа төлөвшүүлэх нэн шаардлагатай байна.

¹ [/en.unesco.org/](http://en.unesco.org/)

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

Үндэслэл

КОВИД-19 цар тахлын үед цахим сүлжээний өргөн боломжийг боловсролын салбарт үр дүнтэй хэрэглэж байгаа хэдий ч цахим сургалт явуулах багшийн арга зүй, мэдээллийн технологийг хэрэглэх чадвар нөгөө талаас сурагчийн сурх зорилгоо ухамсарласан байдал, сурх арга барил, эзэмшсэн чадвар, цахим хэрэгслийн хүртээмж, хувийн сахилга бат, хариуцлага өндөр байхыг шаардаж байна. Манай сургуулийн хувьд цахим хичээлийг зайн сургалтын хэлбэрээр зохион байгуулж байсан ба хичээл сургалтын үр дүн суралцагчдын хичээлд хандах хандлагаас ихээхэн хамаарч байсан. ЕБС-ийн суралцагчидтай харьцуулахад эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хяналт сул байдаг, хөдөө орон нутгийн суралцагчид олон байдаг зэргээс шалтгаалж google meet хичээлд хамрагдах оюутан суралцагчдын тоо бага, багштай эргэх холбоо байхгүй нь тэдний хичээлийн хоцрогдол үүсэх том шалтгаан болсон гэж үзэж байна

Судалгааны ажлын зорилго, ач холбогдол

Энэхүү судалгааны ажлын гол зорилго нь ковид цар тахлын үеийн цахим сургалтын чанар, хүртээмжийг үнэлэх, оюутан суралцагчдын хандлага цахим сургалтын чанарт хэрхэн нөлөөлсөн болон цаашлаад танхимын сургалтын чанарт тэдний хандлага төлөвшлийг дээшлүүлж биеэ даан суралцах чадварыг нэмэгдүүлсэнээр хэрхэн үр дүн гарч болохыг судлахад оршино.

Судалгааны ажлын зорилтууд:

- Хичээлийн хоцрогдлыг 2019-2022 онтой харьцуулан судлах
- Танхим болон цахим хичээлийн ирцийг харьцуулан судлах
- Багшийн цахимаар анги бүрийн группт оруулсан хичээл дээрх оюутан суралцагчдын хандалтыг судлах
- Цахим хичээлийн үр дүн, оролцоо, Google meet хичээлд суухад гардаг хүндрэл бэрхшээлийг нээн илрүүлэх

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

- Оюутан суралцагчдын хандлага үр дүнтэй суралцахад нь хэрхэн нөлөөлдөг болох, тэдний хандлага төлөвшил, өөрөө бие даан суралцах чадварыг дээшлүүлэх

Судалгааны аргууд

- Судалгааны явцад ажиглалт хийх
- Харьцуулалтын арга
- Анкет асуулгын арга
- Нэгтгэн дүгнэх
- Түүвэр судалгааны арга

Нэгдүгээр бүлэг

1.1. ХАНДЛАГА ГЭЖ ЮУ ВЭ ?

Таны бодол, таны амьдралыг харах өнцөг, аливаад хандах хандлага таны өнөөдрийн амьдралыг бий болгож байгаа. Хүний хандлагыг бий болгодог, бэхжүүлдэг олон хүчин зүйлүүд бий. Гэхдээ хандлага гэж яг юуг хэлээд байна вэ? Хамгийн энгийнээр хэлэхэд хандлага бол танд тохиолдож буй аливаа юмс үзэгдэлд таны үзүүлж буй хариу үйлдэл.

1.2. НИЙГМИЙН ТОГТСОН ХАНДЛАГА ГЭЖ ЮУ ВЭ ?

Нийгмийн тогтсон хандлага гэдэг нь олон нийтийн баримжаа хэрэгцээг ухамсрах хэлбэр бөгөөд үнэлэлтийн хоёр дахь хэлбэр¹. Нийгмийн тогтсон хандлага төлөвших үндсэн зам нь бие хүний хувийн туршлага практик амьдралд шууд оролцож нөлөөлөх явдал болно. Үүнд² тогтсон хандлага нь тухайн зүйлд итгэл төгс байх, романтик эрмэлзлэл³, тэмүүлэл ба шүүмжлэлтэй байх зэрэг сэтгэлийн хөдлөлөөр илэрч⁴ хэрэгждэг байна.

Тогтсон хандлага нь ухамсартай буюу ухамсаргүй хэлбэрээр илэрдэг. Мөн зан төлвийн үндсэн дээр бий болдог. Бидний ухамсарт бүр хүүхэд байх үеэс зохион бодохуйн тусламжтайгаар итгэл үнэмшил хүчтэй илэрч сэтгэгдэл төрүүлдэг. Жишээ нь бид хүүхэд байхаасаа хулгана ч юм уу ямар нэг амьтанд дургүй болсон бол тэр тогтсон хандлага насанд хүрсэн хойно ч тэр

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

хэвээрээ байдаг билээ. Тогтсон хандлагын төлөвших үе шатыг Ж.Годфруа дараах байдлаар ялган үзжээ. Үүнд:

12 хүртэлх насанд эцэг эхийн жишээ], загвараар тогтсон хандлага төлөвшинө.

12-20 наснаас тогтсон хандлага нь нийгмийн үүргийг эзэмшихтэй холбоотой хэлбэрээр илүү хөгжинө.

20-30 насанд тогтсон хандлага бүхэлдээ сэтгэцийн тогтвортой шинэ дүр загварыг бий болгож байдаг итгэл үнэмшлийн тогтолцоон дээр тулгуурлан үүсдэг.

Нийгмийн тогтсон хандлага нь дараах үүрэгтэй.

- Дасан зохицох – өөрийн зорилгодоо хүрэх объект руу субъектыг чиглүүлнэ.
- Мэдлэгийн – тодорхой объектод хандах зан үйлийг бий болгоно.
- Өөрийгөө илэрхийлэх[–]хүн өөрийн дотоод дарамтаас чөлөөлөгдөх], өөрийн бие хүнийг бусдад таниулахад тусална.

Хамгаалалтын – бие хүний дотоод зөрчлийг шийдвэрлэх арга болно.

1.3. СУРАЛЦАГЧИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГАТАЙ СУРАЛЦАХУЙН ОНОЛЫН ТАЙЛБАР

Бие даан суралцахуйтай холбоотой нэр томьёо, ойлголт олон янз байдаг. Эдгээрээс хамгийн ерөнхий хэрэглэгдэж буй нь “өөрийн удирдлагатай суралцахуй” юм. Үүнд бие даан суралцахуйг сурагч суралцахуйгаа ойлгох, суралцахуйд сэдэл тэмүүлэлтэй, хариуцлагатай оролцох, багштай хамтран суралцахуйн орчныг бүтэцчилэхэд оролцох зэргийг багтаадаг. Бие даан суралцах гэдэг нь сурагч ганцаараа суралцана гэсэн утга биш юм. Бие даан суралцагч гэдэг нь мэдлэг, мэдээллийг идэвхгүй хүлээн авагч, багшийн зааврыг хүлээгч, багшаас хараат байдалтай суралцагч бус харин өөрийн суралцахуйг удирдан чиглүүлэх, зохицуулах чадвартай, суралцахуйн эксперт түвшинд хүрэх боломж бүхий суралцагч юм.

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

Бие даан суралцахуйн үндсэн элементүүд нь сурагчдын гадаад болон дотоод хүчин зүйлүүдийг агуулж байна. Гадаад хүчин зүйл нь багш, сурагчийн харилцааны хөгжил болон суралцахуйн таатай орчныг бүрдүүлэх явдал юм. МакБет бие даан суралцахуйд шаардлагатай орчны дэмжлэгийн шатлалыг санал болгожээ.



Энд материаллаг орчин гэдэгт анги танхим, номын сан гэх мэт, цаг хугацааны орчин гэдэгт багшийн зүгээс тухайн сурагч тодорхой даалгавар дээр ажиллах хугацааг зааж өгснийг ойлгоно. Үүний дараа сурагчийн бие даан суралцах хүсэл, чадварыг бууруулах, эсвэл нэмэгдүүлж болзошгүй үе тэнгийнхний орчин байна. Дараа нь суралцах бичиг, дасгал ажлын дэвтэр, аудио бичлэг гэх мэт хэрэглэгдэхүүний орчин байна. Эцэст нь багш нарын зан чанар, мэдлэг, ур чадвар, туршлагыг харуулсан багшийн нөөц гэсэн орчууд орно.

1.4 СУРАЛЦАГЧИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГАТАЙ СУРАЛЦАХУЙН ОНОЛЫН ҮЕ ШАТУУД

Өөрийн удирдлагатай суралцахуйн үндсэн 4 үе шат

Алхам 1: Суралцах бэлэн байдлыг үнэлэх

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

Сурагчид бие даан амжилттай суралцахын тулд янз бүрийн чадвар, хандлага хэрэгтэй. Энэ үе шатанд сурагчдад өөрийн өнөөгийн нөхцөл байдал, суралцах зуршил, гэр бүл болон сургуулийн орчинд үзүүлэх боломжит дэмжлэг, орчин, бие даан суралцах өмнөх туршлага зэргийг мэдэх боломж олгоно. Үүний тулд бэлэн байдлын судалгаа хийж болно. Өөрийн удирдлагатай суралцахын тулд сурагч бие даасан, зохион байгуулалттай, сахилга баттай, үр дүнтэй харилцах чадвартай, бүтээлч санал хүсэлтийг хүлээн авч өөрийгөө үнэлэх, өөрийгөө эргэцүүлэн бodoх чадвартай байх шаардлагатай.

Алхам 2: Суралцахуйн зорилгыг тодорхойлох

Сурагч болон багшийн хоорондох суралцахуйн зорилгын харилцаа нь маш чухал. Сурагч зорилгоо тогтоохын тулд өөрийн суралцахуйн өнөөгийн төлөв байдал ямар байгааг мэдэх, суралцахуйн зорилгын замын зургаар бол хаана зогсож байгаагаа, хаашаа явах ёстойгоо мэдэх нь чухал юм. Сурагчийг зорилгоо тодорхойлоход чиглэсэн нэг үр дүнтэй арга бол багш, сурагчийн (зарим тохиолдолд багш, сурагч, эцэг эхийн гуравласан) хооронд суралцах гэрээ байгуулах юм. Суралцах гэрээ нь дараах агуулгыг хамарч болно. Үүнд:

- Суралцахуйн нэгж зорилт
- Үйл ажиллагааны бүтэц, дараалал
- Үйл ажиллагааг дуусгах хугацааны график
- Зорилт бүрийн хувьд ашиглах материал
- Үнэлэх үйл явц
- Зорилт бүр биелэсэн эсэхийг үнэлэх үнэлгээ
- Багштай уулзах, харилцах хуваарь
- Хүлээн зөвшөөрсөн гарын үсэг гэх мэт.

Байгуулсан гэрээний биелэлтийг тогтмол, цаг тухайд нь үнэлэх хэрэгтэй.

Алхам 3: Суралцахуйн үйл явцад оролцох

Сурагч өөрийн хэрэгцээ болон, өөрийн удирдлагатай суралцах зорилгоо маш сайн ойлгосон байх хэрэгтэй. (Learning preference). Сурагч өөрийн суралцах хэв маягийг мэдсэн байвал илүү үр дүнтэй байна. Сурагч дараах асуултад хариулах хэрэгтэй:

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

- Миний хамгийн сайн суралцах арга юу вэ?
- Миний дуртай багш хэн бэ? Яагаад?
- Багш бусад багшаас ялгаатай юу хийдэг вэ?

Сурагч дээрх асуултуудад хариулж, багшдаа өгнө. Мөн тэд өөрсдийн суралцах хандлагаа ойлгох хэрэгтэй:

- Гүн хандлага. Энэ нь өөрийн удирдлагатай суралцахуйд тохирсон хандлага юм. Энэ хандлагаар суралцагч нь тухайн зорилгыг биелүүлэхэд шаардлагатай хэмжээнээс илүүг сурх, асуудлыг ойлгох, мэдлэгээ шинэ нөхцөлд хэрэглэх чадвартай болдог.
- Өнгөц хандлага. Энэ хандлагаар суралцагч нь тухайн зорилгыг биелүүлэх, сэдвийн агуулгаас халихгүй бөгөөд өгсөн даалгаврыг багасгахыг хичээдэг.
- Стратегич хандлага. Энэ нь дүн авах, шалгалтад амжилт үзүүлэх, өндөр оноо авахыг эрмэлзэх хандлага юм.

Уламжлалт сургалтын үе дэх сургалтын даалгаврууд нь сурагчдаас зөвхөн өнгөц болон стратегич хандлагыг шаарддаг байсан. Энэ нь бие даан суралцах чадварыг хөгжүүлэхэд тохиромжгүй юм. Бие даан суралцах нь сурагчаас санаагаа ойлгох, мэдлэгээ шинэ нөхцөлд шилжүүлэн хэрэглэх чадвар бүхий гүн гүнзгий суралцах хандлагыг шаарддаг.

Алхам 4: Суралцахуйг үнэлэх

Сурагч өөрийн удирдлагтай, амжилттай суралцахын тулд өөрсдөө суралцахуйдаа эргэцүүлэл хийх, суралцахуйн зорилт, хийж буй үйл аижллагаандаа өөрийн үнэлгээ хийхэд оролцох явдал чухал. Өөрийн үнэлгээг дэмжихийн тулд:

- Багштай тогтмол зөвлөлдөх
- Санал хүсэлт авах

Сурагчийг сурлагын амжилтын өөрийн үнэлгээнд дараах чиглэлүүдээр оролцуулах Би амжилттай суралцсанаяа хэрхэн мэдэх вэ? Мэдлэгээ уян хатан хэрэглэж чадаж байна уу?] Би хийсэн ажлаа тайлбарлахдаа өөртөө итгэлтэй байна уу? Би хангалттай сайн суралцаж байгаагаа хэзээ мэдсэн бэ? / Xэзээ өөрийгөө үнэлэх, энэ талаар багштайгаа хэдийд зөвлөлдөх вэ? / 4 алхам дахь багш, сурагчийн үүрэг

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

Сурагчийн үүрэг.

- Суралцах бэлэн байдлын өөрийн үнэлгээ хийх
- Өөрийн суралцахуйн зорилгоо тодорхойлж, суралцах гэрээ байгуулах
- Өөрийн суралцах үйл явцыг хянах
- Сургалтын үйл явцын бүх шатанд санаачилгатай оролцох
- Сургалтын явцад өөрийн үнэлгээ хийж, зорилгоо дахин томьёолох
- Багштайгаа тогтмол зөвлөлдөх

Багшийн үүрэг.

- Хамтран суралцах сургалтын орчин бүрдүүлэх
- Сурагч суралцахуйн туршлагаа сэдэлжүүлэх, өөрийн удирдлагатай болгоход туслах
- Сурагчийн оролцоо, санаачилгыг дэмжих
- Суралцах явцад сурагч бүрт тохирсон заавар, зөвлөгөө өгөхөд бэлэн байх
- Зааварлагч байхаас илүүтэй зөвлөн туслагч байх

Бие даан суралцахуй нь сурлагын амжилтыг ахиулах, өөртөө итгэл, суралцах сэдэл, тэмүүллийг өсгөх, өөрийнхөө чадвар, сул талыг мэдэх, суралцах үйл ажиллагаагаа өөрөө удирдан зохион байгуулах зэрэг боломжийг сурагчдад олгодгоороо давуу талтай.

Бие даан суралцах арга зүйг хэрэгжүүлэхийн тулд багшийн зүгээс дараах үйл ажиллагааг явуулна.

- Сурагчийг өөрийгөө үнэлэх боломжоор хангах. Сурагч бурд суралцахуйн замын зураг бий болгож, одоо хаана байгаа, цаашид хаана очихоо мэдэхэд туслах хэрэгтэй.
- Сурагчийг өөрийн суралцахуйн зорилгоо тодорхойлох, сонгох боломж олгох
- Алхам алхмаар ядралгүй суралцах боломжийг төлөвлөн, амжилттай зохион байгуулах. (Явцын үнэлгээнд суурилах, асуулт асуух, харилцах)
- Зан төлөвийн загварыг санал болгох
- Харилцааг хөгжүүлэх
- Анги, гэрийн даалгаврын биелэлт, эргэх холбоог сайжруулах
- Хамтын ажиллагааг дэмжих

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

- Эргэцүүлэлт сургалтын арга хэрэглэх. Өдөр тутмын суралцахуйн үр дүнгийн тэмдэглэл, суралцахуйн гэрээ байгуулах гэх мэт арга хэрэглэх.

Сурагчийн өөрийн удирдлагатай суралцахуйг хэрэгжүүлэх нь сургалтад дараах ач холбогдолтой. Үүнд:


1. Сурагчийн сурах чадварыг нээх, тэдний чадварыг бүрэн хөгжүүлэхийн тулд ганцаарчилсан удирдамж, зааварчилга өгөх боломжтой.
2. Сурагчдыг суралцах, сэтгэх илүү туршлагатай болгоход чиглэсэн заавар, гарын авлага бий болох.
3. Сурагчид ирээдүйд уг чадвар, суралцах арга зүйгээ бусад хичээл, салбарт хэрэглэх чадвартай болно.
4. Богино хугацаанд тодорхой үр дүнд хүрэхийн тулд албан сургалтын бус, нээлттэй хөтөлбөр мөрдөх, суралцах авьяастай хүүхэд бие даан өөрийгөө хөгжүүлэх, бусад сурагчдаас түрүүлж хөгжих боломж олгоно.

Хоёрдугаар бүлэг - Судалгааны хэсэг

2.1 2019, 2020, 2021 оны англи хэлний хичээлийн түвшин тогтоох шалгалтын үнэлгээг харьцуулан судалсан судалгаа

Англи хэлний хичээлээр 2,5 жилийн 1-р курсийн оюутнуудаас жил бүр түвшин тогтоох шалгалт авч анализ хийж суралцагчдын ЕБС-ийн англи хэлний суурь мэдлэгийг тогтоож, хавар хичээл дуусахад ахицыг үнэлдэг. Дараах судалгаа нь танхимаар хичээллэж байсан үеийн элсэлт буюу 2019 оны ТТШ болон 1 жил цахимаар хичээл заалгасан 2020, 2021 онуудад элссэн суралцагчдын түвшинг харуулж байна.

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга
замаар бие даан суралцахуйг дэмжих



Судалгаанаас харахад суралцагчид танхимаар суралцаж байсан 2019 онд өгсөн түвшин тогтоох шалгалтын амжилт чанар 2021 оныхоос тодорхой хувиар илүү байгаа нь харагдаж байна. !!!

2.2 Танхим болон цахим хичээлийн хамрагдалт оролцоог харицуулсан түүвэр судалгаа

Судалгааг Уул уурхайн жишиг сургуулт Полтехник коллежийн 2,5 жилийн ангийн Гагнуур 1а, Авто 1а, НСО 1а, БЦ 2а, БЦ 2а, БЗЧ 2а гэсэн 6 ангийн 94 хүүхдээс 2021 оны 11 сарын сургалтын албаны ирцийн дэвтэрээс түүвэр судалгаа авч анализ хийлээ 6-н ангийн түүвэр судалгааг хүснэгт хэлбэрээр оруулав.

2.5 Жилийн ангийн 11-р сарын танхимын хичээлийн түүвэр судалгаа


№	Анги	Дундаж нэг сарын							
		Гагнуур 1а	НСО 1а	Авто 1а	БЗЧ 2а	БЦ 2а	БЦ 2б	Нийт	Дундаж
1	Нийт хүүхдийн тоо	18	12	18	15	16	15	94	16
	Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	14	11	15	12	14	10	76	13
	Ирцийн хувь	76%	91%	86%	83%	89%	69%	494%	82%

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих


2.5 жилийн ангийн 11-р сарын цахим хичээлийн түүвэр судалгаа

№	Анги	Дундаж 1 сарын							
		Гагнуур 1а	НСО 1а	Авто 1а	БЗЧ 2а	БЦ 2а	БЦ 26	НИЙТ	Дундаж
2	Нийт хүүхдийн тоо	18	12	18	15	16	15	94	16
	Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	3	10	4	1	9	3	30	5
	Ирцийн хувь	19%	83%	25%	7%	84%	33%	251%	42%


11 сарын цахим хичээлийн ирцийн хувь



11 сарын танхимиын хичээлийн ирц хувь



Танхимиын сургалтын ирц болон Цахим сургалтын ирцийг харцуулсан гарфик



Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

Танхим болон цахим хичээлийн хамрагдалт оролцоог харьцуулсан түүвэр судалгааны дүгнэлт

Түүвэр судалгаанаас хархад 6 ангийн танхимын ирцийн дундаж 82% тай байгаа боловч зарим ангийн ирц 70 хүрэхгүй хувь байна. Иймд анги тус бүр дээр авсан түүвэр судалгааг дисперсийг² тооцох аргаар гаргахад гагнуур 1а $\delta_x^2=250$, авто1а $\delta_x^2=151$, НСО 1а $\delta_x^2=74$, БЦ 2а $\delta_x^2=152$ БЦ 26 $\delta_x^2=349$ БЗЧ 2а $\delta_x^2=70$

Түүвэр судалгаанаас хархад 6 ангийн цахимын ирц дундаж 42% тай байгаа боловч зарим ангийн ирц 7 хувь хүрэхгүй байна. Ийм анги тус бүр дээр авсан түүвэр судалгааг дисперсийг тооцох аргаар гаргахад гагнуур 1а $\delta_x^2=590$, авто1б $\delta_x^2=379$, НСО 1а $\delta_x^2=2415$, БЦ 2а $\delta_x^2=2018$ БЦ 26 $\delta_x^2=151$ БЗЧ 2а $\delta_x^2=1331$

Цахим болон танхимын 6 ангийн дисперсийн тооцооллыг³ оруулж өгсөн түүвэр судалгааний дисперс тооцооллын нэгтгэлийг хархад цахим сургалт 2 анги БЦ 2А НСО 2а ангиас бусад ангийн цахим сургалтын хамрагдалт маш хангалтгүй байна. Цахим хичээлийн ирц болон цахим хичээлд ороход гардаг саад бэрхшээлийг тодорхойлох судалгаа / суралцагчдаас /

2.3 Цахим хичээлийн хандалтын судалгаа.,

Судалгааг хичээл ордог 8 анги дээр хийлээ. 2022 оны 3.10 аас цахимд 2 хоног шилжсэнтэй холбоотойгоор тус 8 анgid англи хэлний хичээлийг оруулсан ба 4 хоногийн хандалтыг авч үзвэл

² $\delta_x^2=((x_1 - \bar{x})^2 + (x_2 - \bar{x})^2 + \dots + (x_n - \bar{x})^2) / (n-1) = \frac{\sum_{i=1}^n (x_i - \bar{x})^2}{n-1}$ “Судалгаа шинжилгээний арга зүй” Ч. Авдай, Д.

Энхтуяа х.т 35

³ Хавсралт -1

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих



Chuluunchimeg Avkhuu
March 10 at 9:24 AM ·

1. Write the grammar on the notebook.
2. Do exercise of Present perfect tense

PRESENT PERFECT TENSE

S + have/has + past participle
I have tried sushi.

S + have not (haven't)/has not (hasn't) + past participle
I have not tried sushi.

Have/Has + subject + past participle?
Have you tried sushi?

POSITIVE (+)	NEGATIVE (-)	QUESTIONS (?)
I have been checked.	I haven't been checked.	Have I been checked?
We have been checked.	We haven't been checked.	Has been checked?
They have been checked.	They haven't been checked.	Has been checked?
It has been checked.	It hasn't been checked.	Has been checked?
We have been checked.	We haven't been checked.	Has been checked?
They have been checked.	They haven't been checked.	Has been checked?
They have been checked.	They haven't been checked.	Has been checked?

www.englishstudyhere.com

Usage

- To express things you have done in your life
- To express number of times you have done something
- To describe recently completed actions which are important now
- To express situations that started in the past and are still true
- To describe unfinished actions or situations
- To express present result

Example

- She has never studied Japanese.
- How many times have you tried to call her?
- I have some bad news. I've lost my job.
- I've known James for 4 or 5 years.
- I've read half of the book.
- John has missed the bus, so he'll be late.

Нийт 8 ангийн 96 хүүхэд хичээлд хандалт хийх ёстойгоос



Судалгаанаас харахад нийт ангиудын хичээлийн хандалт 50 иас дээш хувьтай байгаа боловч даалгаврын гүйцэтгэлийн хувь болон багштай эргэх холбоо байхгүй байгаа нь суралцагчдын хандлага тааруу байгаа нь харагдаж байна.


2.4 Цахим хичээлийн ирц болон цахим хичээлд ороход гардаг саад бэрхшээлийг тодорхойлох судалгаа [суралцагчдаас]

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга
замаар бие даан суралцахуйг дэмжих

Судалгааг 5 асуулгатайгаар 6 ангийн группт **Google form** хэлбэрээр байршуулсан
ба судалгаанд нийт 23 суралцагч хамрагдсан.


1. Ангия сонгоно уу

22 responses



2. Энэ хичээлийн жилд цахим сургалтын хэдэн хувьд нь хамрагдсан бэ?


23 responses



Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих


3. Цахимаар орсон хичээлийн дасгал даалгаврыг хийхэд ямар хүндрэл гардаг вэ? /3-аас дээш хариулт сонгож болно/

23 responses




4. Багшийн цахимаар өгсөн даалгаврыг хугацаанд нь хийж гүйцэтгэдэг үү?

23 responses



5. Цахим хичээл ямар хэлбэрээр байвал та нарын сонирхолыг илүү татдаг вэ?


22 responses



Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

6. Цахим хичээл хийх явцад багшийн урамшуулал дэмжлэг байдаг уу

23 responses



Дээрх судалгаанаас үзэхэд нийт судалгаанд хамрагдах суралцагчдын 24 хувь нь хамрагдсан байна. Цахим хичээлдээ идэвхтэй оролцдог ангиудын судалгааны хандалт өндөр байгаа нь харагдаж байна. Суралцагчдын хариултаас харахад цахим хичээлийн 80-100 хувь хамрагддаг гэж 39,1 хувь нь хариулсан байна. Цахимаар орсон хичээлийн дасгал даалгаврыг хийхэд ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ гэсэн асуултанд нийт оролцогчдын 22,6 хувь нь цахимаар суралцахад хүндрэлтэй, дата нэгж байдаггүй гэж хариулсан байна. Багшийн цахимаар өгсөн даалгаврыг хийж гүйцэтгэдэг үү гэсэн асуулгад 52 хувь нь тийм гэсэн хариултыг өгсөн байна. Цахим хичээл хийх явцад багшийн урамшуулал дэмжлэг байдаг уу гэсэн асуулгад тийм болон заримдаа гэсэн хариултыг ихэнх хувь нь сонгосон байна.

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

Дүгнэлт

Бие даан суралцах чадвар хүн бүрт төрмөл байдаг. Тэр төрмөл чадвараа өдөөж, тогтмол ашиглаж байвал энэ чадвар улам бүр өсч нэмэгдэж байдаг хэмээн ШУ-ны доктор Т.Уранчимэг өгүүлсэн байдаг. Багш бид бүхэн сургалтын хоцрогдол үүссэн, суралцагчдын хичээлд хандах хандлага тааруу байгаа талаар ам амандаа ярьдагч ямар нэг дорвитой ажил хийхгүй байгаа нь нууц биш юм. Цаашид бид бүхэнд дахин цахимаар сургах, зайнаас хичээл сургалтаа явуулах хэрэгцээ шаардлага тулгарахыг үгүйсгэх аргагүй юм. Өөрийн гэсэн онцлогтой боловсролын түүчээ болж буй багш бид бүхэн мэргэжлийн боловсролын салбарын хичээл сургалтыг чанартай хүртээмжтэй явуулахад анхаарч ажиллах хичээл сургалтын хоцрогдлыг арилгах шинэ арга зүй, төлөвшил хүмүүжлийг бии болгох цаг нэгэнт иржээ. Манай сургуульд суралцдаг оюутан суралцагчдын хувьд 21 аймаг, сум дүүргээс ирдэг эцэг эхийн хараа хяналтаас хол биеэ даан суралдаг онцлогтой ба дээрх олон талын судалгаанаас харахад тэдний бие даан суралцах чадвар дутмаг, хандлага тааруу байгаа нь харагдаж байна. Мэргэжилтэй, цаашид өсөн дэвших чадвартай төгсөөгчдийг бэлтгэн гаргахад нөлөөлөх нэг том хүчин зүйл нь тэдний хандлага төлөвшил юм. Орчин үеийн сургалтын арга барил нь багш зөвхөн чиглүүлэгч дэмжигч байж суралцагч төвтэй байхыг шаардаж байгаа хэдий ч энэ нь тийм ч үр дүнтэй бус байгаа нь цар тахлын үеийн хичээл сургалтын үйл ажиллагаанаас харагдаж байлаа. Багш орчин үеийн техник технологи ашиглан маш их цаг хугацааг комьютерийн ард өнгөрөөж хичээл бэлдсэн ч түүнд хандах оюутан суралцагчдын хандлага тааруу байгаа нь эхлээд бид бүхэн суралцагчдын хандлага, биеэ даан суралцах тал руу нь илүү анхаарах, ажиллах шаардлагатайг харуулж байна.

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга
замаар бие даан суралцахуйг дэмжих

Дэвшүүлэх санал

- Танхимын хэлбэрээр хэвийн хичээллэж эхлэхэд уламжлалт ба цахимд суурилсан хосолсон сургалтыг оновчтой хэрэгжүүлэх замаар гэнэтийн шаардлагын улмаас үүссэн онлайн сургалтын сул тал, сөрөг үр дагавруудыг бууруулах сорилтууд бидний өмнө тулгарч байна. Иймээс сургууль, багш нар уламжлалт танхимын болон хосолмол, холимог сургалтын хэлбэрүүдийг сургалт, үйл ажиллагаандaa эрчимтэй нэвтрүүлэх бэлэн байдлыг хангах, мөн шинэ мэдлэг мэдээллийг эрэлхийлж ажиллахын тулд дараах зүйлд анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:
 - Сурагчдын суралцах нөхцөл байдал, сурлагын хоцрогдлыг оношлох
 - Сурагчийн өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжих
 - Уламжлалт танхимын сургалтын арга зүйд ахиц өөрчлөлт гаргах
 - Хосолсон сургалтын хэлбэрүүд, тэдгээрийн сургах зүйн дидактик зарчмыг ойлгох
 - Багшлах боловсон хүчнийг бэлтгэх
- Хүүхэд бүрийн өвөрмөц нандин онцлог, хэрэгцээ, сонирхлыг таньж, ойлгож, хүлээн зөвшөөрч, хөгжлийг дэмжиж, давуу талд нь суурилж ажиллах нь багшийн үүрэг. Иймд хүүхдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, бүх хүүхдийг (хүйсийн ялгаа, хөдөлмөр эрхэлдэг хүүхэд, үндэсний цөөнхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зэрэг) боловсрол эзэмших тэгш боломжоор хангах, ялгаатай нөхцөл байдал (жендэр, нийгмийн гарал, угсаа, суралцах чадварын түвшнээс хамаарсан), ялгаатай хэрэгцээнд нийцсэн хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь чухал. Хүүхдүүд оюуны чадамж, биеийн хөгжлийн чадвар, хэл соёлын ялгаа, онцгой авьяас, ар гэрийн дэмжлэг, өөрийгөө удирдах, илэрхийлэх, өөртөө итгэлтэй байх, харилцах, бие даан суралцах зэрэг ялгаатай чадваруудаасаа шалтгаалаад өөрийн хэрэгцээнд тохирсон боловсролын чанартай үйлчилгээг бүрэн дүүрэн авч чадахгүйд хүрдэг. Иймээс бүх сурагчийн оролцоо, амжилтыг хязгаарлаж буй саад бэрхшээлийг арилгаж, ялгаатай хэрэгцээ, чадвар, онцлог чанаруудыг нь хүндэтгэсэн, тэдний сурх боломжийг дэмжсэн, уян хатан, олон хувилбартай арга хэлбэр бүхий сургалтын арга барилыг хэрэгжүүлэх


Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

шаардлага тулгарч байна. Ялгаатай суралцахуй бол сурагчдын мэдлэгийн түвшин, мэдлэгийг хүлээн авах байдал нь өөр, мөн шинэ мэдээлэл болон чадварыг өөрийн сонирхлоос шалтгаалан хүлээн авч боловсруулах аргын хувьд ялгаатай болохыг хэлж байна:

3. Анги удирдсан багш нарыг чадавхижуулах сургалтыг нэн тэргүүнд явуулах шаардлагатай байна. Судалгаанаас харахад зарим ангийн ирц болон хичээлийн оролцоо сайн байгаа нь ангийн багшийн ангитай ажиллах чадвар сайн байгааг харуулж байна.

Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

Оюутан суралцагчийн хичээлийн хоцрогдолыши арилгах сургалтын аргачлал



Сургалтын чанарт оюутан суралцагчдын хандлагад нөлөөлөх арга замаар бие даан суралцахуйг дэмжих

Ашигласан ном материал

1. ЕБС-ийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөн, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааны удирдамж
2. Судалгаа шинжилгээний арга зүй” Ч. Авдай, Д. Энхтуяа
3. <http://sciencepark.gov.mn/>
4. www.mlsp.gov.mn
5. www.meds.gov.mn
6. <http://bagsh.itpd.mn/>
7. www.orloo.info
8. setgelmn.wordpress.com
9. <http://www.mier.mn/>
10. [www. Google.com](http://www.Google.com)
11. Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2019-2021 оны статистик мэдээ
12. Чанартай сургалт- чавдарлаг мэргэжилтэй ажилтан 2015 он
13. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх зөвлөмж 2016 он

No	AHRI	Өәеп	2	4	9	11	16	18	23	25	30			hніт	ЛVH4ак
Hніт	ХҮХАНИНГИЙН ТОО	18	18	18	18	18	18	18	18	18	18			162	16
TҮХАНН ӨАӘП ХАМПАРАЧАН	XҮХАНИНГИЙН ТОО	2	3	4	2	3	5	3	6	3				31	3
ӨБАТЫН														0	0
ЯНГОӨТСИН														0	0
TАСАРЧАХ		16	15	14	16	15	13	15	12	15				131	15
TҮСРЭПДАУТАХАЛ ГАНРАА														0	0
NДҮҮНИНХ ҮҮБ														172	19

2.5 КИРЖИНХ АХРИНН 11-Р САГБИН ТАХНМОБИ НХАССАНИНХ ТҮҮБЭП СҮГААРАА

No	AHRI	Өәеп	1	3	5	8	10	12	15	17	19	22	24	26	29
Hніт	ХҮХАНИНГИЙН ТОО	18	18	18	18	18	18	18	18	18	18	18	18	18	234
TҮХАНН ӨАӘП ХАМПАРАЧАН	XҮХАНИНГИЙН ТОО	12	15	18	12	14	13	14	18	11	10	12	18	10	177
ӨБАТЫН		1			1			1		1		2		2	1
ЯНГОӨТСИН		2				1		2		3		2			15
TАСАРЧАХ		1				5		4		1		2		6	25
TҮСРЭПДАУТАХАЛ ГАНРАА		2					1		4		1		1		9
NДҮҮНИНХ ҮҮБ			67	83	100	67	78	72	78	100	61	56	67	100	56

2.5 КИРЖИНХ АХРИНН 11-Р САГБИН ТАХНМОБИ НХАССАНИНХ ТҮҮБЭП СҮГААРАА

Хабсагат -1

2.5 жилийн ангийн 11-р сарын танхимын хичээлийн түүвэр судалгаа

No	Анги	Өдөр	1	3	5	8	10	12	15	17	19	22	24	26
1	НСО 1а	Нийт хүүхдийн тоо	12	12	12	12	12	12	12	12	12	12	12	12
		Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	11	11	12	11	12	10	11	10	11	10	11	12
		Өвчтэй							1			2	2	
		чөлөөтэй	1	1				1	1	1			2	
		Тасалсан								2				
		Тусгаарлалтанд байгаа				1		1	1		1			
		Ирцийн хувь	92	92	100	92	100	83	92	83	92	83	92	100

2.5 жилийн ангийн 11-р сарын цахим хичээлийн түүвэр судалгаа

No	Анги	Өдөр	2	4	9	11	16	18	23	25	30			
2	НСО 1а	Нийт хүүхдийн тоо	12	12	12	12	12	12	12	12	12			
		Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	10	11	10	10	9	10	10	8	10			
		Өвчтэй												
		чөлөөтэй												
		Тасалсан												
		Тусгаарлалтанд байгаа	2	4	2	4	3	2	2	4	4			
		Ирцийн хувь	83	92	83	83	75	83	83	67	83			

2.5 жилийн ангийн 11-р сарын танхимын хичээлийн түүвэр судалгаа

No	Анги	Өдөр	1	3	5	8	10	12	15	17	19	22	24	26
1	HCO 1a	Нийт хүүхдийн тоо	12	12	12	12	12	12	12	12	12	12	12	12
		Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	11	11	12	11	12	10	11	10	11	10	11	12
		Өвчтэй							1			2	2	
		чөлөөтэй	1	1				1	1	1			2	
		Тасалсан								2				
		Тусгаарлалтанд байгаа				1		1	1		1			
		Ирцийн хувь	92	92	100	92	100	83	92	83	92	83	92	100

2.5 жилийн ангийн 11-р сарын цахим хичээлийн түүвэр судалгаа

No	Анги	Өдөр	2	4	9	11	16	18	23	25	30			
2	HCO 1a	Нийт хүүхдийн тоо	12	12	12	12	12	12	12	12	12			
		Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	10	11	10	10	9	10	10	8	10			
		Өвчтэй												
		чөлөөтэй												
		Тасалсан												
		Тусгаарлалтанд байгаа	2	4	2	4	3	2	2	4	4			
		Ирцийн хувь	83	92	83	83	75	83	83	67	83			

2.5 жилийн ангийн 11-р сарын танхимын хичээлийн түүвэр судалгаа

No	Анги	Өдөр	1	3	5	8	10	12	15	17	19	22	24	26	29	нийт	Дундаж
1	Авто 16	Нийт хүүхдийн тоо	18	18	18	18	18	18	18	18	18	18	18	18	18	234	18
		Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	12	12	17	13	17	18	15	18	12	15	18	18	16	201	15
		Өвчтэй														0	0
		чөлөөтэй														0	0
		Тасалсан	5	5		4	1		3		5	2			2	27	2
		Тусгаарлалтанд байгаа	1	1	1	1					1	1				6	0
		Ирцийн хувь	67	67	94	72	94	100	83	100	67	83	100	100	89	1116.667	86

2.5 жилийн ангийн 11-р сарын цахим хичээлийн түүвэр судалгаа

No	Анги	Өдөр	2	4	9	11	16	18	23	25	30					нийт	Дундаж
2	Авто 16	Нийт хүүхдийн тоо	18	18	18	18	18	18	18	18	18					162	18
		Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	6	5	4	5	3	4	3	6	4					40	4
		Өвчтэй														0	0
		чөлөөтэй														0	0
		Тасалсан	12	13	14	13	15	14	15	12	14					122	14
		Тусгаарлалтанд байгаа														0	0
		Ирцийн хувь	33	28	22	28	17	22	17	33	22					222.2222	25

2.5 жилийн ангийн 11-р сарын танхимын хичээлийн түүвэр судалгаа

No	Анги	Өдөр	1	3	5	8	10	12	15	17	19	22	24	26	29	нийт	Дундаж
1	Б3Ч 2а	Нийт хүүхдийн тоо	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	195	15
		Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	13	13	13	11	12	12	12	15	9	11	12	15	14	162	12
		Өвчтэй							1						1	2	0
		чөлөөтэй												1		1	0
		Тасалсан	2	2	2	4	3	3	2		6	4	2			30	2
		Тусгаарлалтанд байгаа													0	0	
		Ирцийн хувь	87	87	87	73	80	80	80	100	60	73	80	100	93	1080	83

2.5 жилийн ангийн 11-р сарын цахим хичээлийн түүвэр судалгаа

No	Анги	Өдөр	2	4	9	11	16	18	23	25	30					нийт	Дундаж
2	Б3Ч 2а	Нийт хүүхдийн тоо	15	15	15	15	15	15	15	15	15					135	15
		Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	3	1	2	0	1	0	1	1	2					11	1
		Өвчтэй													0	0	
		чөлөөтэй													0	0	
		Тасалсан	12	14	13	15	14	15	14	14	13				124	10	
		Тусгаарлалтанд байгаа													0	0	
		Ирцийн хувь	20	7	13	0	7	0	7	7	13				73.33333	8	

2.5 жилийн ангийн 11-р сарын танхимын хичээлийн түүвэр судалгаа

No	Анги	Өдөр	1	3	5	8	10	12	15	17	19	22	24	26	29	нийт	Дундаж
1	БЦ 2Б	Нийт хүүхдийн тоо	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	195	15
		Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	11	12	11	7	9	10	10	8	7	12	12	15	11	135	10
		Өвчтэй	3	2	2	2	3		2	2	2	1	1			20	2
		чөлөөтэй	1								2	2				5	0
		Тасалсан		1	2	6	3	5	3	5	3		2		3	33	3
		Тусгаарлалтанд байгаа									1				1	2	0
		Ирцийн хувь	73	80	73	47	60	67	67	53	47	80	80	100	73	900	69

2.5 жилийн ангийн 11-р сарын цахим хичээлийн түүвэр судалгаа

No	Анги	Өдөр	2	4	9	11	16	18	23	25	30					нийт	Дундаж
2	БЦ 2Б	Нийт хүүхдийн тоо	15	15	15	15	15	15	15	15	15					135	15
		Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	4	5	6	3	5	6	7	5	4					45	5
		Өвчтэй														0	0
		чөлөөтэй														0	0
		Тасалсан	11	10	9	12	10	9	8	10	11					90	7
		Тусгаарлалтанд байгаа														0	0
		Ирцийн хувь	27	33	40	20	33	40	47	33	27					300	33

2.5 жилийн ангийн 11-р сарын танхимын хичээлийн түүвэр судалгаа

№	Анги	Өдөр	1	3	5	8	10	12	15	17	19	22	24	26	29	нийт	Дундаж	Дисперс
1	БЦ 2а	Нийт хүүхдийн тоо	16	16	16	16	16	16	16	16	16	16	16	16	16	208	16	
		Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	11	13	16	14	16	16	16	15	15	12	14	14	13	185	14	
		Өвчтэй	1			2										3	0	
		чөлөөтэй	1									2	1	1	2	7	1	
		Тасалсан	1	1												2	0	
		Тусгаарлалтанд байгаа	2	2						1	1	2	1	1	1	11	1	
		Ирцийн хувь	69	81	100	88	100	100	100	94	94	75	88	88	81	1156.25	89	152

2.5 жилийн ангийн 11-р сарын цахим хичээлийн түүвэр судалгаа

№	Анги	Өдөр	2	4	9	11	16	18	23	25	30					нийт	Дундаж	Дисперс
2	БЦ 2а	Нийт хүүхдийн тоо	16	16	16	16	16	16	16	16	16					144	16	
		Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	14	12	13	14	15	13	14	13	13					121	9	
		Өвчтэй														0	0	
		чөлөөтэй														0	0	
		Тасалсан	2	4	3	2	1	3	2	3	3					23	2	
		Тусгаарлалтанд байгаа														0	0	
		Ирцийн хувь	88	75	81	88	94	81	88	81	81					756.25	84	2018

2.5 жилийн ангийн 11-р сарын танхимын хичээлийн түүвэр судалгаа


№	Анги	Дундаж нэг сарын								
		Гангуур 1a	НСО 1a	Авто 1a	БЗЧ 2a	БЦ 2a	БЦ 26	НИЙТ	Дундаж	
1	Нийт хүүхдийн тоо	18	12	18	15	16	15	94	16	
	Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	14	11	15	12	14	10	76	6	
	Ирцийн хувь	76	91	86	83	89	69	494	82	

2.5 жилийн ангийн 11-р сарын цахим хичээлийн түүвэр судалгаа


№	Анги	Дундаж 1 сарын								
		Гангуур 1a	НСО 1a	Авто 1a	БЗЧ 2a	БЦ 2a	БЦ 26	НИЙТ	Дундаж	
2	Нийт хүүхдийн тоо	18	12	18	15	16	15	94	16	
	Тухайн өдөр хамрагдсан хүүхдийн тоо	3	10	4	1	9	5	32	2	
	Ирцийн хувь	19	83	25	7	84	33	251	42	

Анги	Гангуур 1a	НСО 1a	Авто 1a	БЗЧ 2a	БЦ 2a	БЦ 26	НИЙТ	Дундаж
ИРЦ хувь	76	91	86	83	89	69	494	82

11 сарын танхимын хичээлийн ирц хувь



11 сарын цахим хичээлийн ирцийн хувь



Танхимины сургалтын ирц болон Цахим сургалтын ирцийг харцуулсан гарфик

